

## МОНГОЛ ДАХЬ ЦЭРЭГ-ЗАСАГ ЗАХИРГААНЫ ӨӨРЧЛӨЛТ, ЧИГ ХАНДЛАГА (XX ЗУУНЫ ТЭРГҮҮН ХАГАС)

Ж.Болдбаатар

Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Түүхийн тэнхим.

**Өгүүллийн товч утга:** XX зууны тэргүүн хагасын Монгол дахь цэрэг-захиргааны өөрчлөлт бол нэгд: Чин улсын эрхшээлд байсан үеийн цэрэг-захиргааны зохион байгуулалт, хоёрт: үндэсний тусгаар тогтнолоо олж, өөрийн гэсэн цэрэг-захиргааг дахин сэргээсэн боловч, эргэн алдарсан үе, гуравт: Монгол оронд үндэсний ардчилсан хувьсгал ялан мандаж, төрийн захиргааны шинэ тогтолцоо бүрэлдсэн үеийг хамарсанаараа өвөрмөц онцлогтой юм.

**Түлхүүр үг:** Цэрэг, засаг захиргаа, жанжны газар, амбан сайд, жанжин, аймаг, хошуу, сум, арми.

### **I. XX зууны эхэн үеийн Монголын цэрэг-засаг захиргааны зохион байгуулалт**

XX зууны эх гэхэд Монгол орон Манж чин улсын эрхшээлд байж, түүний цэрэг-засаг захиргааны зохион байгуулалтын бүрэлдэхүүн хэсэг болж байв. Чин улсын "Шинэ засгийн бодлого" нь Монголын байгалийн баялагийг империалист том гүрнүүдтэй нийлж цөлмөх, газар нутаг бэлчээрийг нь хагалбарлан тариалах, энэ зорилгоор хятад иргэдийг үй олноор шилжүүлэн суурьшуулж, монголын уугуул хүн амыг хятадчлах, улмаар манж-хятадын засаг захиргааны шууд дотоод муж болгон хувиргахад чиглэж байсан юм. Энэ үед Монголын орныг Бээжин дэх Гадаад Монголын төрийг засах явдлын яам болон цэрэг-захиргааны төв аппарат шууд эрхлэн захирч, нутаг дэвсгэр-засаг захиргааны хувьд аймаг, хошуу, тамгатай хутагтын шавь болгон хувааж байв.

**Манж Чин улсын хаан монголын газар нутгийн болон төрийн дээд эзэн нь байж,** засаг ноёдод хошуу нутаг хуваарилан, түүнийг үе улиран эзэмших эрх олгодог байжээ. Мөн Манжийн хаан монгол ноёдыг хараат түшмэгээ гэж үзэж, хэргэм зэрэг шагнах, угсаа залгамжлах, албан тушаалаас нь огцруулах, аймаг, хошуу байгуулах, нутгийн хил зааг тогтоох, цаазлах зэргээр Монголын төрийн дээд эрх мэдлийг бүрэн эдэлж, улаан бийрээр цохож зөвшөөрөл соёрхол олгодог байсан юм.

**Лифань Юань буюу "Гадаад Монголын төрийг засах явдлын яам буюу" Манжийн төрийн төв зургаан яамтай нэг зиндаанд байж, Төв засгийн ордныг төлөөлөн, Монголын асуудлаар зарлиг буулгах эрхтэй байсан.** Тус яам Ар Монголыг Улиастайн жанжин, Их Хүрээ болон Ховдын сайдын газруудыг дамжуулан захирч, үйл ажиллагаагаа явуулдаг байв. Зарим тохиолдолд аймгуудын чуулган дарга нартай шууд харилцаж, захиран удирдана. ГМТЗЯЯ нь засаг ноёд, тайж нарын хэргэм зэрэг залгамжлах, тэднээс манж хаанд өсөн цагааны алба барих, аливаа ёслол гүйцэтгэх, хууль цаазыг хэрэгжүүлэх, мөн элдэв нэмэлт өөрчлөлт хийж, хаанд айлтгах зэрэг ажлыг эрхэлдэг байв.

**Улиастайн жанжны газар нь Ар Монголд байгуулагдсан Манж Чин улсын хамгийн дээд эрхтэй байгууллага юм.** 1780 онд Улиастайн жасаа жанжнаас Сэцэн хан аймгийн чуулганы газар явуулсан бичигт "Улиастайн жанжин нь ...хязгаар дахинд холбогдсон чухал хэргийг шийтгэх, дөрвөн аймгийн цэргийн хэргийг захирах, өртөө харуулыг цагдах, оргодол босгуулыг байцаан барих зэрэг хэргийг товчлон захирах үүрэгтэй" /1/ хэмээжээ.

Улиастайн жанжнаар эхлээд ганц нэг монгол хүн томилогдож байснаа сүүлдээ манж хүмүүс дагнан суух болжээ. Сайхь жанжны дараа түүний туслах зөвлөгчид - манж, монгол хуувийн сайд нар орно.



Улиастайн жанжны газар Ар Монголын нийт аймаг хязгаарыг бүхэлд нь шууд хариуцаж байснаа Их Хүрээ, Ховдын сайдын газар байгуулагдснаас хойш Засагт хан, Сайн ноён хоёр аймаг, Хөвсгөл нуурын ба Тагна урианхайн хэргийг шууд харъяалах болжээ. Гэхдээ Ар Монголын хэргийг ерөнхийд нь хариуцсан дээд газар хэвээр үлдсэн билээ.

Их Хүрээнд эхний үед Манж сайд байгаагүй бөгөөд харин Өндөр Богдыг харгалзах нэрээр хиа, бичээч нарыг суулгаж, ерөнхий хяналт тавьдаг байжээ. Хожим 1758 онд монгол сайд, 1761 онд манж сайд тус тус томилж, Их Хүрээний сайдын газар байгуулжээ. Их Хүрээний сайд Түшээт хан, Сэцэн хан аймаг, Богд Жибзундамба хутагтын шавийн хэргийг эрхлэхээс гадна Их Хүрээ, Хиагтын жургааны зангийг хамааран захирч, бас Оростой харилцах явдлыг хянан байцаах үүрэг хүлээж байв.

**Манж Чин улс 1762 онд Ховдын хязгаарын монголчуудын хэргийг эрхлүүлэхээр Ховд хотноо Манж сайдын газрыг нээжээ.** Манжийн хааны зарлигт: "Зарлигаар зарсан Ховдод сууж хэрэг шийтгэх сайд" /2/ гэж тэмдэглэжээ. Ховдын амбан нь тус сайдын газар Дөрвөд хоёр аймаг, Алтайн урианхайн 7 хошуу, Торгууд 2 хошуу, Захчин, Мянгад, Өөлдийн тус бүр нэгжгээд хошуу бүхий Ховдын хязгаарын хэргийг эрхлэх болжээ. Энэ сайдын дэргэд Халхын дөрвөн аймаг, дөрвөд хоёр аймгийн жасаад сууж, холбогдох газар хүн ардаас алба татвар хариуцан гаргах үүрэг хүлээж байсан байна.

Манж сайдын газар нь эдгээр захиргааг "Хүрээний жургааны занги", "Хиагтын жургааны занги"-ийн газар нэрлэж байсан боловч, гүйцэтгэж байсан үүргээрээ "Хүрээний заргач", "Хиагтын заргач" гэж нэршсэн байна. Эл газар хятад иргэдийн хэрэг төдийгүй, аймаг хошуу, шавиас томилогдсон түшмэлүүдтэй хамтран манж, хятад, монгол хүмүүсийн хооронд үүдэн гарсан зарга заальхайг шүүн тасалж байсан байна.

**Манжийн эрхшээлийн үед аймаг, хошуу, сум гэсэн монголын уламжлалт нэр томъёог засаг захиргааны шаталсан нэгж болгон ашиглажээ.** XVI зууны дунд үеэс XVII зууны эцэс хүртэл оршин тогтнож байсан Халх долоон хошуу нь баруун, зүүн гар болон хуваагдаж, Түшээт хан, Сэцэн хан, Засагт хан хэмээх гурван том ноёны эзэмшилд хамаарагдах болжээ.

Халхын зүүн гарын ноён Абтай /1554-1588/ Түмэн засагт хааны даалгавраар 1577 онд Хөх хотноо заларч, Далай лам Содномжамцтай нүүр учран шарын шашинд сүслэн ороод, түүнийг Халхад дэлгэрүүлэхээр хэлэлцэн тохирчээ. Үүний хариуд Далай лам Абтай ноёнд Очирай бат Түшээт хан хэмээх цол өргөмжилжээ. Халхын Түшээт хан хэмээн нэрлэгдсэн учир энэ буюу. Үүний дараа Халхын зүүн гарын бас нэг ноён Гэрсэнзийн V хүү Амин-Дуралын ач Шолой /1577-1662/ өөрийгөө хан гэж өргөмжлөн, Сэцэн хан гэж алдаршжээ. Түүнчлэн баруун гарын том ноён Лайхур биеэ хан өргөмжлөн Засагт хан гэгдэх болсон байна. Ийнхүү Халхад бараг нэгэн зэрэг гурван хан бий болж, Халхыг хуваан захирах болсон билээ. 1691 онд чуулсан Долоннуурын чуулганаар Ар Монголыг Манжийн харъяат болгоод дээр дурьдсан Халхын гурван ханаар толгойлуулсан гурван аймгийг зохион байгуулж, тэдгээрийг Түшээт хан, Сэцэн хан, Засагт хан аймаг гэж нэрлэх болов. 1692 онд Чин улсын цэргийн бодлогод захируулан, Түшээт хан аймгийг Халхын хойт зам, Сэцэн хан аймгийг Халхын дорно зам, Засагт хан аймгийг Халхын баруун зам болгосон байна. Энэ нь Чин улсын цэргийн зохион байгуулалтын Юан улсын үеэс уламжлан авсан том нэгж юм.

1725 онд Ойрадтай байлдахад "гавъяа" байгуулсан Сайн ноён, чин ван Дашдондовт Түшээт хан аймгаас 19 хошуу таслан өгч нэгэн шинэ аймгийг байгуулжээ. Тэрхүү аймгийг Сайн ноён гэж нэрлээд, халхын дундад зам болгосон байна. Ингэж Халхын дөрвөн аймаг бий болжээ. Аймаг нь хошуу, тамгатай хутагтын шавь гэсэн засаг захиргааны үндсэн нэгжүүдээс бүрдэнэ.



Үүнд: Түшээт хан аймаг 20 хошуу, Сэцэн хан аймаг 23 хошуу, 1 тамгатай хутагтын шавь, Засагт хан аймаг 19 хошуу, 3 тамгатай хутагтын шавь, Сайн ноён аймаг 24 хошуу, 7 тамгатай хутагтын шавьтай байв.

**Манж нар Ойрадыг эзэлсний дараа Дөрвөдийг зүүн, баруун гар болгон, хоёр аймгийг шинээр байгуулж, Халхад харъяалуулжээ.** Эдгээрийн зүүн гарыг Далай хан аймаг, баруун гарыг Үнэн зоригт хан аймаг хэмээн нэрлэсэн байна. Ингэж Гадаад Монгол зургаан аймагтай болсон ажээ. Үүнээс гадна Алтайн урианхай, Хөвсгөл нуурын урианхай, тагна урианхай, өөлд, мянгад, захчин, торгууд нь аль ч аймагт харъяалагдахгүй тусгай захиргаатай байсан билээ.

Манж нар 1728 онд Халхын аймгуудыг тус бүр нэгжгээд чуулган болгож, нийлэх газрыг тогтоож өгчээ. Эхний үед аймгийн чуулган даргын тушаалд аймгийн ханыг томилж байгаад сүүлдээ нэгэн засаг ноёныг тохоон тавьдаг болсон байна. Ингэснээр аймгийн ханы эрх мэдэл эрс буурч, чуулганы даргад захирагдах бусад засаг ноёдоос бараг ялгагдахаа болив.

Аймгийн чуулган нь манж жанжин, амбасын хяналтын дор тухайн аймгийн бүх хэргийг зөвлөлдөн шийдвэрлэх газар юм.

Чуулган дарга нь тухайн аймгаа засаг захиргааны хувьд ерөнхийлөн захирахаас гадна шүүх таслах явдлыг эрхэлнэ. Түүнээс гадна аймаг бүрт цэргийн хэргийг эрхэлсэн "аймгийн туслагч жанжин", "хэбэй" ажиллаж байжээ. Тэд Улиастайн жанжинд шууд захирагдаж, чуулган дарга нартай адил эрх эдэлж байсан байна. Аймгийн жанжин бүр өөр өөрийн тамга, тугтай. Аймгийн чуулган дарга, жанжин нар зарим үед ГМТЗЯЯ-тай шууд харилцах эрхтэй байжээ.

Манжийн ноёрхолын үед уламжлалт бус "жасаа" /Ээлж гэсэн манж үг. Ж.Б./ нэртэй хэд хэдэн газар байгуулагдсан юм. Жасаанд очсон дөрвөн аймгийн засаг, түшмэдүүд нь 3-6 сарын хугацаагаар ээлжлэн суудаг байсан тул тийнхүү нэрлэжээ. Тухайлбал: "Аймгийн да, жанжны жасаа", "Хүрээн дэх суурин ба хэрмэлийн жасаа", "Улиастайн 4 аймгийн жасаа", "Ховдын халхын жасаа" болно. Эдгээр жасаа нь тухайн аймгийн чуулган дарга, жанжны тушаал, шийдвэрийг биелүүлэх гүйцэтгэн захирах байгууллага болж байлаа.

**Манжийн эрхшээлийн үеийн засаг захиргааны үндсэн нэгж нь хошуу болж байсан юм.** Манжийн эрхшээлд орох үед Халх нь 8 хошуунаас бүрдэж байсан бол сүүлдээ олон жижиг хуваагдаж, Ховдын хязгаарыг нэмээд 125 хошуутай болсон байна. Захиргаа-цэргийн нэгж болох хошууг угсаа залгамжилсан Засаг ноён захирч, тамгын газрын тусламжтайгаар удирдан зохион байгуулж, шүүн таслах үйл ажиллагаа явуулж байв. Засаг ноён гол төлөв ван, бэйл, бэйс, гүн гэсэн хэргэмтэй байсан. Үүнийг Манжийн төрийн хэтэрхий дөрвөн хэргэм гэж нэрлэдэг. **Хошуу дотсрхи нэгж нь сум бөлгөө.** 1691 онд Манж нар Халхад хошуу, сум зохиосноор "сум" хэмээх засаг захиргааны анхан шатны нэгж үүсчээ. Сум нь цэрэг, иргэний шинжтэй зохион байгуулалтын хэлбэр юм. Манжийн хууль ёсоор сум нь цэргийн насны 150 эрийн тоогоор байгуулагдана. Лам, шавь хамжлагаас бусад 18-60 насны эрчүүд цэрэг эрд тооцогдоно. 150 тооны цэргийн насны эрээр сум зохиогоод үлдсэн нь дээрх тоонд хүрэхгүй бол хагас сум зохионо. Үүнийг "хондого" гэж нэрлэдэг.

Сум нь дотроо арванд хуваагдана. Арван хэмээх нэгжийг аравны дарга хариуцна. Энэ нь арван эрийн дотроос томилогдож байсан.

Тайж нар зэрэг дэвийнхээ дагуу хамжлага захирах бөгөөд тэд сум эрийн зохион байгуулалтад оролцдоггүй, тусгай отог буюу баг болж 1705 оноос хойш төрлийн дарга хэмээх ахлагч томилж, түүнд захирагдан явжээ. Төрлийн дарга нь хошуу тамгын газар шууд харъяалагдана (3,177-178).

VIII Богд Жибзундамба хутагтын шавь тусгай захиргаатай байсан. Шавийн захиргааны хэргийг Эрдэнэ шанзудбын яам эрхэлж байсан. Их шавь хэмээн нэрлэгдэнэ. Түүнээс гадна 13 тамгатай хутагт, түүний шавь нар нь сум эрийн



дансанд орохгүй, тусгай зэс тэмдэг зураг бүхий нутагтай, бие даасан захиргаатай, хошуутай адил эрх хэмжээтэй, аймгийн чуулганы газар шууд захирагддаг байжээ.

Энэ дашрамд тэмдэглэхэд, Манжийн эрхшээдийн үеийн Монголын цэрэг-захиргааны зохион байгуулалт нь: 1. Монголчуудыг хараат түшмэг улсын байдалтай байлгаж байсан үе (1636 оноос XVIII зууны сүүлч үе). 2. Монголд хагас колонийн засаг захиргаа тогтоосон үе (XIX зууны эхнээс сүүлч хүртэл). 3. Манж чин улс Монголыг засаг-захиргааны хувьд бүрэн колонийн засаг захиргаа тогтоох буюу шууд өөрийн дотоод муж болгох бодлогсо хэрэгжүүлж эхэлсэн үе үеүдийг (XIX зууны сүүлчээс XX зууны эх) дамжин төлөвшиж иржээ. Эл үйл явц дараах онцлогтой байв. Үүнд:

- Эхний үе нь XVII зууны эхний хагасаас XIX зууны сүүлч хүртэл 160-аад жилийг хамарч, Манж чин улсын бусад хязгаар муж, хойт хөрш-Хаант Орос улсаас тусгаарлагдсан, тодорхой хил-хязгаартай, орох, гарахад тусгай зөвшөөрөлтэй зорчдог, улс орныхоо дотоодод "Халх журам" хэмээх өөрсдийн тогтоосон хуулинд захирагддаг, эзэнт гүрэнд төлөх алба татвар алдаг оног байсан. Энэ нь нэг талаас, Манж нар эхэн үедээ нүүдлийн болон суурьшмал иргэд бүхий их хэмжээний газар нутагтай их гүрнийг удаан тогтоон барина гэдэгтээ итгэхгүй байсан учраас хэрэв суурьшмал хэсгээ алдвал улсаа нүүдэлчдийн гүрний хэмжээнд эерэг байдлаар хандаж байсантай холбоотой. Нөгөө талаас, Манжийн хаан хүртэл өөрөө шавь орсон I Богд Жибзундамбын ухаалаг бодлого, нэр нөлөөтэйямар нэг хэмжээгээр холбоотой.

- Манж нар өөрийн цэрэг-засаг захиргааны зохион байгуулалтынхаа зарим нэг зүйлийг манайд тулган хүлээлгэсэн боловч, Монголын аймаг, хошуу, тэр ч байтугай эртний уламжлалт аравтын тогтолцоог хэвээр нь авч хэрэглэжээ. Харин улс төрийн хувьд монголчуудыг нэгдэж нягтрахаас болгоомжлон, Монголыг олон жижиг хошуунд хуваан бутаргажээ.

- Манж нар бурханы шашин, Монгол дахь түүний тэргүүн лам удаа дараагийн Богд Жибзундамбын шавийн захиргааг зохих хэмжээнд бэхжүүлэх бодлого барихын хамт тэрхүү их ламтны нэр нөлөөг хэмжээ хязгааргүй болгохгүйн тулд орон нутаг дахь тамгатай хутагтуудын засаг захиргааг мөн нэгэн адил санхүүгийн талаар дэмжиж байсан.

- XIX зууны эхэн үе гэхэд Монгол дахь Манжийн цэрэг-захиргааны тогтолцоо хагас колонийн хувьд бүрэн механизмаараа ажиллах болсон. Харин XIX зууны сүүлч XX зууны эх гэхэд Манж чин улс "Шинэ засгийн бодлого" гэгчийг явуулж, Монголыг цэрэг-засаг захиргааны хувьд өөрийн дотоод муж болгох замд шилжжээ.

## **II. Шинэ тулгар Монгол улсын цэрэг-засаг захиргааны өөрчлөлт**

1911 оны үндэсний хувьсгалын үр дүнд тусгаар тогтнолоо дахин сэргээсэн Монгол улс төрийн хэлбэрийн хувьд шашин, төрийг хосолсон хэмжээгүй эрхт хаант засгийг сонгон авчээ. VIII Богд Жибзундамба хутагтыг шинэ тулгар Монгол улсын хаанаар өргөмжилсөн байна. Богд гэгээнийг хаан сэнтийд залсан нь; 1.Үндэсний эрх чөлөөний хувьсгалыг удирдан манлайлагчийн нэг байсан; 2.Тэрбээр Монголын бурхны шашны тэргүүний хувьд тэртээ тэргүй сүсэгтэн олны оюун санааны удирдагч байсан; 3.Чингис хааны удам-Өндөр гэгээний хойт дүр гэж өргөмжлөгдсөн учраас хэдийгээр төвд хүн гэсэн ч алтан ургийн холбоотой хэмээн тооцогдож байсан; 4.Захирах шавь хамжлага, хөрөнгө чинээгээр Халхад хамгийн баян чинээлэг нь байсан; 5.Монголын нийгмийн бүх бүлэг, давхраа түүнийг тойрон хүрээлэхээс биш, эн зэрэгцэн хаан ширээ булаалдах ноёд төдий л байхгүй зэргийг харгалзан үзсэн юм. Түүнийг анх эзэн хааны эрдэнийн сууринаа залрахад айлтгасан ерөөлийн



үгэнд: "Монгол улсын эзэн, шашин төрийг хослон барьсан наран гэрэлт, түмэн наст Богд хаан" хэмээн өргөмжилсөн байна.

Богд хаан дотоод, гадаад, цэрэг, сан, шүүх гэсэн таван яам бүхий Засгийн газрыг байгуулж, олон улсын парламентаризмын жишгийг баримтлан, Улсын дээд, доод хурлыг байгуулсан байна. Эдгээр хурал нь хаанд зөвлөх эрхтэй байлаа.

Орон нутгийн засаг захиргааны хуваарийн хувьд Манжийн ноёрхолд байсан үеийн бүтэц, хэлбэрийг үндсэнд нь хэвээр хадгалан үлдсэн боловч, харийн хааны эрх, амбан сайдын хараа хяналтад бус, өөрийн улсын эзэн хаан, түүний засгийн газрын шууд удирдлагаар орон нутгийн засаг захиргааны нэгжүүд ажиллах болжээ. Гэхдээ орон нутгийн засаг захиргааны тухайд бага сага өөрчлөлт хийсэн байна. Тухайлбал, Хан уулын чуулганыг Богд хан хайрхан уулын чуулган, Бидэръяа нуурын чуулганыг Хан Тайшир уулын чуулган, Хэрлэн Барс хотын чуулганыг Хан Хэнтий уулын чуулган болгон тус тус өөрчилсөн байна. Цэцэрлэгийн чуулганыг хэвээр үлдээж, Дөрвөдийн зүүн гарын Бат-ерөөлт төгс хөлөг Далай хан аймаг, баруун гарын Үнэн зоригт хан аймаг чуулах газраа тухай бүр өөрсдөө сонгож байхаар тогтоожээ. Зургаан аймгийн чуулган гурван жилд нэг удаа чуулах бөгөөд албан тэгшитгэх, чуулган дарга дэвшүүлэх зэрэг аймгийн холбогдолтой элдэв чухал асуудлыг хэлэлцэнэ.

Чуулган даргыг харъяат чуулганы засаг хан, ван, бэйл, бэйс, засаг бус ван, гүнгүүдийн дотроос сонгож, хааны зарлигаар тавьж байв. Чуулган даргын газар зохих тооны түшмэдтэй. Чуулган дарга хошуудын түшмэлийг батлах, аймаг улсын алба хэрхэн явагдаж байгааг хянах, өртөөний албыг зохицуулах, хошууны засгийн эрх мэдлээс давсан элдэв хэргийг барагдуулах зэрэг олон асуудлыг эрхэлж байжээ.

Цэргийн хэргийг аймгийн жанжин эрхэлнэ. Жанжин тавихад чуулган даргатай нэг адил хааны зарлигаар гүйцэтгэнэ. "Хууль зүйлийн бичиг"-т: "Түшээт хан аймгийн жанжинд шулуун цагаан өнгөт туг нэг, Сэцэн хан аймгийн жанжинд шулуун шар өнгөт туг нэг, Засагт хан аймгийн жанжинд шулуун улаан өнгөт туг нэг, Сайн ноён хан аймгийн жанжинд шулуун хөх өнгөт туг нэг, Дөрвөд далай хан аймгийн жанжинд хөвөөт цагаан өнгөт туг, Дөрвөдийн үнэн зоригт хан аймгийн жанжинд хөвөөт шар өнгийн туг нэг тус тус байгуул. Басхүү тэмдэгт сум, өөр өөрийн 12 үүсгэрийг тархааж олгогтун" (4,27) гэж заажээ.

Мөн Улиастай, Ховд, Хиагтад хэрэг шийтгэгч сайдын яамыг байгуулсан байна. Эдгээрийн хэрэг шийтгэгч сайдыг Дотоод яамнаас сонгон айлтгаж тавьж, төрийн яамны дэд сайдын зиндаанд ажиллуулж байжээ.

"Хууль зүйлийн бичиг" ёсоор Хаант Монгол улс засаг захиргааны зохион байгуулалтын хувьд Жибзундамба хутагтын 30 отог, Түшээт хан аймгийн 21 хошуу, Сэцэн хан аймаг 25 хошуу, 2 отог шавь (Эрдэнэ ялгуулсан хутагт, Егүзэр хутагт), Засагт хан аймаг 20 хошуу, 3 отог шавь (Жалханз хутагт, Ялгуусан хутагт, Номун хан хутагт), Сайн ноён хан аймаг 25 хошуу, 8 отог шавь (Зая бандид хутагт, Эрдэнэ бандид хутагт, Чин сүжигт Номун хан Эрдэнэ хамба ноён хутагт, Эрдэнэ мэргэн ноён хутагт, Нару банчин хутагт, Наран хутагт, Хамба хутагт Номун хан, Шива ширээт хутагт), Дөрвөдийн зүүн гарын Бат-ерөөлт төгс Далай хан аймаг 12 хошуу, зүүн гарын Үнэн зоригт хан аймаг 15 хошуутай байхаар заажээ. Чингэлхээр Олноо өргөгдсөн Монгол улс 6 аймаг, 118 хошуу, Богд Жибзундамба болон тамгатай хутагтын 56 отог шавиас бүрэлдэж байв (3,6-11).

Олноо өргөгдсөн Монгол улсын цэрэг-засаг захиргааны зохион байгуулалт нь дараах онцлогтой байв. Үүнд:

- Манжийн эрхшээлээс өмнө эх сууриа тавьж, босоо тэнхлэгээр хангай, говь хээр хосолж зохион байгуулагдсан Халхын дөрвөн аймаг, мөн арай хожим бий болсон 100 гаруй хошууд нь он цагийн элэлээр аж ахуй, засаг захиргааны

зохистой хэлбэр болохоо харуулсан учир үндсийг нь эвдэн өөрчлөх онц шаардлагагүй гэж үзсэн,

- Хэдийгээр цэрэг-засаг захиргааны зохион байгуулалт урьдах үеэс хэлбэрийн хувьд онц өөрчлөгдөөгүй мэт боловч агуулгын хувьд улс үндсээ гэсэн эрмэлзлэл бүхий бие даасан шинжтэй болсон,

- Орон нутаг дахь цэргийн зохион байгуулалтын хэлбэрийг хэвээр хадгалж, харин төвдөө үндэсний байнгын армитай болох эхлэлийг тавьсан,

- Хэлбэрийн хувьд шашин, төрийг хосолсон, хэмжээгүй эрхт хаант засаг тогтсон учир цэрэг-засаг захиргааны бүх шатанд шашин ёс, ёслолын шинжтэй зүйл нэвтэрч байсан. Тухайлбал, Сангийн яам улаан сахиус Намсрайг, Цэргийн яам улаан сахиус Жамсранг, Гадаад яам хор номхотгогч улаан Аюушийг шүтэн болгож байсан гэх мэт.

- Бүгд Найрамдах Засгийн тухай үзэл санаа дэргэрэх тусам засаг, захиргааг сонгон байгуулах нь зүйтэй гэсэн үзэл газар авах төлөв бүхий болж байсан болой.

### **III. 1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын дараах засаг захиргааны өөрчлөлт**

1919 оны сүүлчээр Монгол орныг гэмин цэрэг эзэлж, хятадын цэргийн эрхтний харгис дэглэм тогтсон юм. Монголын ард түмний үндэсний ухамсар эрс идэвхжиж, 1918, 1919 оны заагаар Хүрээний, Консулын болон Ноёдын хэмээх улс төрийн бүлэглэлүүд бүрэлдсэн байна. Эхний хоёр бүлэг хэрэг явдлын санаачилгыг гартаа авч, шинэ тогтох төрийн тухай асуудлыг боловсруулахдаа эхлээд хөрөнгөтний Бүгд найрамдах засгийн тухай (5,9), 1921 оны III сард Монгол Ардын Нам байгуулагдмагц ардын эрхт сонгуулийн эрхэлсэн гүрэн байгуулах (6,16) үзэл санааг дэвшүүлсэн юм. Энэ ялдамд Монгол Ардын Нам хувьсгалын дараа тогтох цэрэг-засаг захиргааны зохион байгуулалтын асуудлыг боловсруулжээ.

1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын үрээр Монгол оронд хэмжээт цаазат хаант засаг тогтов. Шинэ тулгар Монгол улсын Засгийн газар 1924 он хүртэл орон нутгийн засаг захиргааг ардчилсан үндсэн дээр өөрчлөх нүсэр ажлыг амжилттай зохион байгуулжээ. Түүнчлэн Байнгын цэрэг армийг бий болгов.

1924 онд Улсын I их хурал хуралдаж, I Үндсэн хуулиа батлан, Бүгд найрамдах Улсыг тунхаглажээ. Анхдугаар Үндсэн хуулийн үзэл санааны дагуу төв, орон нутгийн засаг захиргааны өөрчлөлт хийсэн байна. Энэ үеэс Монгол улсын орон нутгийн засаг захиргааны үндсэн нэгж нь арван гэр, баг, сум, хошуу, аймаг болжээ.

**1924 оноос өмнө засаг захиргааны хуваарилалт нь цэрэг захиргааны шинжтэй байсан бол дурьдан буй үед аж ахуй, захиргааны шинжээр зохион байгуулагдах болсоноороо онцлог юм.**

1923-1924 онд орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудыг байгуулж, хошуудад угсаа залгамжлах ёсыг халжээ. Бас шинэ хошуудыг ч нэмж байгуулагджээ. Халх дөрвөн аймгийн хошууд 1918 онд 102 байсан бол 1924 онд 116 болжээ. 1923 оны эхээр харуулуудыг татан буулгаж, нутгийг нь язгуурын харьяат хошуудад олгож, харуулын албаныхны саналаар нь язгуурын хошуудад буюу идээшсэн нутаг хошуунд нь захируулжээ (7, 195).

1924 оноос эхлэн хошууны хүн амын олон цөөн, газар нутгийн байдлыг харгалзан жижгүүдийг нь нэгтгэж, жигдлэх, арга хэмжээ авснаар хошуудын тоо цөөрчээ.

1925 онд Их шавийг татан буулгаж, Дэлгэр их уулын аймгийг байгуулсан ба Их шавийн отгуудыг хошуу болгож өөрчилж, тамгатай 13 хутагтын шавь нарыг хошууны зохион байгуулалтад оруулж бие даасан хошуу болгох буюу зэргэлдээ хошуудад нэгтгэсэн аж. 1926 онд дээрх Дэлгэр Их уулын аймгийг



өөрийн гэсэн тодорхой нутаг газаргүй учир татан буулгажээ. 1927 онд багийг татан буулгаж, 4-өөс доош сумтай жижиг хошуудыг зэргэлдээх хошуудад нэгтгэжээ. 1929 онд сумыг томсгон 300 өрхөөр байгуулах болж аравныг хорин болгон өөрчилсөн байна.

1925-1930 онд БНМАУ-ын нутаг дэвсгэр, засаг захиргааны хуваарилалтад гарсан дээрх өөрчлөлтийн үрээр хуучин хошууд бараг эвдэрч, тэдгээрийн дотоод зохион байгуулалт, хүн ам, хил хязгаар, сав ихээхэн шинэчлэгдэж, аймаг, хошууд нь том хэмжээний зохион байгуулалтанд орсон байна. Энэ үйл явдал нь улсын сан хөрөнгө хомс нимгэн, боловсон хүчин дутагдалтай байсан нөхцөлд төсөв зардал, орон тоог хэмнэх, засаг захиргааны байгууллагуудын ажлыг хөнгөн шуурхай болгоход чухал ач холбогдолтой болжээ.

Үүний дараахнаас том аймаг, хошууд нь улс орны эдийн засаг, соёлыг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх, төрийн удирдлагын үйл ажиллагаанд тохиромжтой бус гэж үзэн, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг дахин өөрчлөх асуудал тавигдаж эхэлсэн байна.

1931 оны II сарын 6-нд "Тус улсын дэвсгэр газрыг шинэчлэн ангилж хуваах тухай хууль" батлагдан гарчээ. Энэ хуулийн дагуу хийсэн өөрчлөлтөөр "хошууг" устгаж, аймаг 5, сум 513 байсныг аймаг 13, сум 311 болгов. Үүний дараах жилүүдэд ч зарим өөрчлөлт хийсэн бөгөөд 1934 онд Алтай аймгийг татан буулгаж, 1940 онд дахин сэргээн байгуулж, Сэлэнгэ, Хөвсгөл зэрэг аймгаас зарим сумдыг тасалж 1938 онд Булган аймгийг, казах, урианхайн иргэдээс гол төлөв бүрдсэн Баян-Өлгий аймгийг тус тус байгуулсан байна.

1921 оны үндэсний ардчилсан хувьсгалын дараа төлөвшин тогтсон засаг захиргааны зохион байгуулалт нь дараах онцлогтой байв. Үүнд:

- 1923-1924 онд явуулсан орон нутгийн засаг захиргааг ардчилах үйл явцын үр дүнд өмнө байсан цэрэг-засаг захиргааны шинжтэй хуваарь аж ахуй, засаг захиргааны шинжтэй болон өөрчлөгдсөн,

- Энэ үед аймаг, сум, арван гэрээс гадна сум, арван гэрийн дунд баг хэмээх нэгжийг бий болгож, хошууг устгасан,

- Зүүний нугалаа завхралын жилүүдэд (1930-1932 он) төрийн захиргааны нүсэр бүтэц бий болгох бодлого явуулж, аймгийн тоог олшруулж, хошууг устган, хэдэн зуугаар тоологдох сумдыг байгуулан, нутаг дэвсгэр, засаг захиргааны хуваарийг улам жижиглэсэн нь яваандаа эдийн засгийн хөгжилд сөрөг нөлөө үзүүлсэн,

- 1931 оны орон нутгийн засаг захиргааны зохион байгуулалтын үндэс эдүгээ хүртэл онц өөрчлөлтгүй мөрдөгдсөөр байна. харин монгол Улсын их хурлаас саяхан бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлахдаа том аймаг, хошууд болгон хувааж байсан хуучин уламжлалаа харгалзан үзсэн болой.

**Abstract:** The changes in military and civic administration in the early half of the 20th century Mongolia featured the following specifics: first, the military and civic administration structure during the domination by Qing Empire, second, the period of reclaiming the lost independence and national statehood, as well as the period of losing the national sovereignty, and third, the victory of the National Democratic Revolution and subsequent reorganization of the new state administration structure.

**Ном зүй**

1. Монгол улсын Үндэсний түүхийн архив. фа-2, хн-16. х.183.
2. Дэндэв Л. Манжийн үеийн албан бичигт гардаг зарим үгсийн тайлбар.УБ., 1954.
3. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын түүх. боть III. Дэд дэвтэр. УБ., 1968.
4. Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг. УБ., 1995.
5. Монгол Ардын Хувьсгалт Намын түүхэнд холбогдох баримт бичгүүд. /1920-1940/. I дэвтэр. УБ., 1966.
6. Монгол Ардын Хувьсгалт Намын Их, Бага Хурал, Төв Хорооны бүгд хурлуудын тогтоол, шийдвэр. I хэсэг. УБ., 1956.
7. Санждорж М. Ардын төрийн түүх. УБ., 1974.